

## Шведэд орогнол хүсэгчийн анхааралд

Энэ хуудаснуудын дээр та, хууль ёсны журмаар бөгөөд Шведэд орогнох болон оршин суух эрх ямар шалтгаанаар өгдгийг уншиж мэдэж чадна.

Таны өргөдлийг хүлээн авч шийдэх нь Цагаачлалын алба юм. Та орчуулагчийн бөгөөд хуулийн туслалцаа ер нь авах эрхтэй.

Цагаачлалын албанаас танд мэдүүлж тогтоосон цаг хугацаанд ирж өөрийгээ хэн бэ гэдгийг ярих нь чухал байна. Та өөрийнхөө газар улсаас дүрвэн гарсны бүх шалтгаанаа хэлж өгөх ёстой.

Та байрны асуудлаар бөгөөд ямар нэг хэмжээгээр эмнүүлхийн талаар тусламж авах эрхтэй болно. Хэрэв өөрийгээ хэн бэ гэдгийг хувийн үнэмлэх бичиг баримтаар нотлож үзүүлбэл та ажил хийх эрхтэй болно.

**Шведэд орогнолын өргөдлийг эхлээд Цагаачлалын албанд хэлэлцэн шийддэг. Ямар хүн орогнол хүлээн авч чадна гэсэн тухай журам НҮБ-ийн дүрвэгчийн конвенц, Шведийн гадаадын иргэний хуульд бичигдэж заасан байгаа. Түүнчлэн хэрэв та Цагаачлалын албанаас татгалзсан хариу авбал та өргөдлөө шүүхэд шийдүүлэх эрхтэй. Энэ шүүхийг цагаачлалын шүүх гэдэг юм.**

**Таны өргөдлийг хаана шийдэх талаар Цагаачлалын алба шалган хэлэлцэж болно**

Эхлээд Цагаачлалын алба таны өргөдлийг Шведэд эсвэл өөр нэг оронд шийдэх ёстойг шалган хэлэлцнэ.

Европын ихэнх улсууд орогнолын өргөдлийг аль улсад шийдэх асуудлаар дундын журам мөрдхөөр зөвшөөлцсөн. Тиймд та Шведээс явах хэрэгтэй болж магадгүй. Тэгээд таны орогнолын шалтгааныг өөр нэг улсад шийднэ. Та өөрийн орогнох өргөдлийг зөвхөн аль нэг улсад л шийдүүлэх эрхтэй юм.



Дараах тохиолдолд та өөр нэг оронд биеэр явж очих, эсвэл хүргүүлэгдэх шаардлагатай юм.

Үүнд:

- та тус улсад орогнох өргөдөл гаргасан
- та тус улсын виз эсвэл түр оршин суух эрх авсан
- та тус улсын газар дэвсгэрт хууль бусаар нэвтэрсэн
- таны гэр бүлийн хүмүүс Шведээс өөр аль нэгэн улсад оршин суух зөвшөөрөл авсан
- таны гэр бүлийнхний хэн нэгэн ЕХ-ны өөр аль нэгэн улсад орогнох өргөдөл гаргаж анх татгалзсан хариу аваагүй

Таны өргөдөл Шведэд хянаж үзвэл Цагаачлалын алба таны хэлж өгсөн шалтгааныг оршин суух эрх авахын тул хангалттай хэмжээний мэдээлэл болох эсэхийг шалгаж хэлэлцэнэ.

**Хурууны хээ**

ЕХ-ны гишүүн орнууд болон Исланд, Норвеги, Швейцар улсуудад Евродак гэдэг компьютерийн хурууны хээ бүртгсэн мэдээллийн сан бий. Шведэд тус мэдээллийн сангийн хариуцагч бол Цагаачлалын алба юм. Хэрэв та орогнол хүсэх бөгөөд 14-өөс дээш насны хүн бол хурууны хээгээ үлдээж өгөх ёстой. Дараа нь түүнийг мэдээллийн санд оруулж та аль нэг тус компьютерийн мэдээллийн сангийг хэрэглэдэг өөр улсад орогнол хүсч байсан эсэхийг хурууны хээгээр шалгадаг. Та компьютерийн санд байгаа мэдээлэлтэй танилцах бөгөөд Цагаачлалын албатай холбогдож тэр мэдээллийг засруулахыг шаардах боломжтой юм. Шведийн алба болсон компьютерийн мэдээллийн асуудлын хороо нь ямар нэгэн бүртгэлд тодрож орсон хүний хувийн мэдээг хянах алба юм.

Цагаачлалын алба таны хурууны хээг өөр нэг SIS (Шенгений Мэдээллийн Систем) компьютерийн мэдээллийн санд оруулж шалгана. SIS-д бүртгэгдсэн хүмүүсийн дотор гэмт хэрэг үйлдснээс эрэн сурвалжилаж буй этгээд байх юм.

### **Орогнолын өргөдлийг судлах**

Анхны хугацаанд Цагаачлалын алба таныг хэдэн удаагийн уулзалтад дуудаж болно. Цагаачлалын албанаас танд тогтоож мэдүүлсэн цаг хугацаанд ирж авах нь чухал юм. Орогнолын өргөдлийг судлах бөгөөд таны өргөдөлтэй хамаатай өнгөрсөн амьдралын тухай ондоо ярианд таныг дуудаж болно. Тус уулзалтад та яагаад орогнол хүсч байгаа бүх шалтгаанаа ярьж өгөх ёстой.

Танаас өөрийнхөө газраас орогнож гарсны бүх учир шалтгааныг танаас өөр хэн ч мэдэхгүй. Үүнд анхнаасаа аван газар орондоо тантай юу юу болсныг тодорхой ярих нь чухал юм. Ингэвэл Цагаачлалын алба таны өргөдлийн асуудлын шалтгаанд зөв шийдвэр гаргаж өгч чадна.

Таны биеийн тухай Цагаачлалын алба асууж сонирхоно. Та иргэний паспорттай эсвэл үнэмлэхтэй байх ёстой. Таны өвөг нэр, хэзээ хаана төрсөн, аль улсын иргэн болохыг бичиг баримтаа нотлож хариулах ёстой. Та яагаад орогнол хүсэх бөгөөд тантай юу болсныг заавал тодорхойгоор хэлж өгөх хэрэгтэй. Зарим зүйлийн тухай ярих нь хэцүү мэдээж. Тиймэрхүү хэрэг тохиолдоход түүнийг хэлж өгөх нь онц чухалтай юм. Тийм хэрэг гарвал таны хүсэлтийг шалгаж хэлэлцэхийн явцад завсар хийхийг асууж болно.

Мөн таны өгүүлэхтэй ямар нэг чухал ач холбогдолтой юм байвал таны яриаг баримтласан зүйлийг бөгөөд улс орныхоо тухай сонин мэдээлэл та нэмж хэлж чадна.

### **Хуулийн туслалцаа**

Орогнол хүсэгчидийн ихэнх нь хуулийн туслалцаа авах эрхтэй. Энэ бол та дэмжлэг болох хүнийг хүлээн авах эрхтэй юм. Үргэлж тохиолдолд тийм хүн бол таны эрх ашиг өмгөөлөх хууль цаазын мэргэжилтэн хүн.

Танд дэмжлэг болох улсаас томилсон өмгөөлөгчийг Цагаачлалын алба гаргана. Тэгэхдээ та өөр нэг таны итгэсэн өмгөөлөгчийг дэвшүүлж бас чадна. Цагаачлалын алба өмгөөлөгчийн зардлыг төлнө.

Тийм өмгөөлөгч бол Цагаачлалын алба болон улсын бусад албатай харьцахдаа тэдэнтэй ямар нэг холбоогүйгээр бие дааж ажиллана.

Хэрэв та улсаас томилох өмгөөлөгчийг хүлээн авах эрхгүй бол та өөрийнхөө өмгөөлөгчийг хөлслөн авч болно. Энэ тохиолдолд түүний зарлыг та өөрөө төлөх юм.

### **Орчуулагч орчуулдаг**

Та Цагаачлалын албатай харилцахад орчуулагч ажилладаг. Орчуулагч төвийг сахиж зөвхөн хүний хэлснийг л орчуулах ёстой. Орчуулагч ажилдаа өөрийн хувийн, улс төрийн эсвэл шашны үзэл бодлоо оролцуулах эрхгүй. Хэрэв та орчуулагчийг ойлгохгүй бол үүний тухай хэлэх ёстой.

### **Та өөрийнхөө хэрэгт тусалж чадна**

Цагаачлалын албаны танд мэдүүлж тогтоосон цаг хугацаанд ирэх нь чухал юм. Тэгвэл та өргөдлийнхөө хариу авахыг хурдлаж магадтай. Тогтоосон уулзалтад орчуулагч болон өмгөөлөгч ер нь байдаг юм.

Хэрэв бүх учрынхаа тухай анхнаас эхлээд хэлж өгвөл та хэргийнхээ явцад нөлөөлж чадна. Та өөрийнхөө хэлээр бичсэн материалаа өгч чадна. Хэрэгтэй бол цагаачлалын албаны газар түүнийг орчуулна.

Цагаачлалын албанд өөрийгөө хэн бэ гэдгийг тодорхой болгохын тулд паспортаа буюу бусад үнэмлэхээ өгөх нь чухал.

### **Цагаачлалын албаны ажилтнууд таны хэргийн нууцыг хадгалах үүрэгтэй**

Цагаачлалын албаны ажилтнууд таны хэн бэ гэдгийг болон орогнох шалтгааныг тань бусдад илчлэх эрхгүй. Тэд нууц хадгалах мэргэжилийн үүрэгтэй.

Энэ нь бол таны тухай мэдээллийг зөвхөн хуулиар зөвшөөрсөн хүмүүст өгч болно утгатай юм. Түүнчлэн орчуулагч, улсаас томилох өмгөөлөгч болон орогнол



хүсэгчидтэй ажиллах өөр хүмүүс нууц хадгалах үүрэгтэй. Тэд таны нэр, хаяг эсвэл орогнол хүсэх шалтгааныг илчлэх эрхгүй.

### **ЛМА гэдэг карт**

Хэрэв та Шведэд орогнох өргөдөл гаргаж өгсөн бол та өргөдөл гаргсаны тухай баримт цаасаар олгогдох юм. Хэд хоногийн дараа танд ЛМА гэдэг карт олгоно. Энэ карт өмнө өгсөн баримт цаасыг орлож таныг орогнол хүсэгч бөгөөд өргөдлийн асуудлыг шийдүүлэх хугацаанд тус улсад байх эрхтэйг гэрчилнэ. Энэ картаар та эмнэлгийн газарт очихдоо баахан мөнгө төлж болно.

Танд оршин суух эрх олговол, эсвэл та өргөдөлдөө татгалзсан хариу авч Шведийг орхин явах ёстой болбол ЛМА гэдэг картыг хариу буцааж өгөх ёстой.

### **Удиртгал**

Таныг хэдэн удаа дуудаж хүлээхийн хугацаанд юу мэдэх хэрэгтэй гэдгийг хэлж өгнө.

### **Орон сууцны газар**

Оргонол олгох өргөдлийг өгчихөөд та өөрөө ч орон сууцны байр олж чадна, эсвэл цагаачлалын албаны байгуулгаар олсныг ашгалж болно. Та өөрөө байх орон сууцны газрыг сонгох эрхгүй, хүлээх хугацаанд өөр газар руу явуулж магадгүй. Та өөрийнхөө байранд суудаг бол, өөрөө мөнгө нь төлөн, өөрөө хоол унд хувцасаа худалдаж авна.

Тантай холбоо барихын тулд хаягаа, утасны дугаарыг заах нь чухал байна.

### **Ажиллах**

Ажил хийх тулд та АТ-UND гэдэг үнэмлэхтэй байх ёстой. Энэ бол ажиллах зөвшөөрлийн үүргээс чөлөөлөгдсний тэмдэг.

Дараах тохиолдолд та ажил хийх эрхтэй болно. Үүнд:

- таны өргөдлийг Шведэд үзэх юм
- та өөрийгөө хэн болохоо бичиг баримтаараа нотлох эсвэл өөрийгөө хэн бэ гэдгийг тогтооход өөрийн зүгээс идэвхтэй оролцоно
- таны өргөдөл сайн батлагдсан, таны өргөдлийг үзэх нь учиртай байна, орогнол олгохыг эргэлзлэх учир байхгүй юм байна.

Хэрэв ажиллах эрх олговол, таны ЛМА картанд бичигднэ. Хэрэв таны өргөдлийг татгалзвал тус улс орныг орхин явах эсвэл өөрөө тус улсаас гарч явахаа хүсч үүнд өөрийн зүгээс туслаж оролцож болтол та ажлаа хийсээр байж болно. Таны өргөдөлд зөвшөөрөл өгвөл та ажлын эрхтэй болж ажлаа үргэлжүүлж болно.

Сул орон тоо олохоор хөдөлмөрийн биржид хандаж болно. Хөдөлмөрийн биржийн [www.arbetsformedlingen.se](http://www.arbetsformedlingen.se) хаягтай веб-хуудсанд сул орон тоо олж болно.

Хэрэв танд АТ-UND байхгүй бол, та ажлынхаа газарт практик хийж чадна. Нэмэлт мэдээллийг авахын тулд цагаачлалын албаны газраас асуу.

### **Мөнгөн санхүү**

Хэрэв танд мөнгө, эд таваар, ажил байхгүй бол, та өдрийн тэтгэлэг авах өргөдөл бичиж чадна. Хэрэв өдрийн тэтгэлэг цагаачлалын албаны газраас авах юм бол, мөнгө нь банкний картын дансанд ирнэ.

### **Эрүүлийг хамгаалах. Эмнэлгийн тусламж**

Эмнэлгийн түргэн тусламжтай байх болон амны хөндийг эмнүүлэх эрхтэй. Эрүүлийг хамгаалах ба эмнэлгийн тусламж хүргэх үүргийг Ландстингет (Landstinget) гэдэг албан байгууллага хариуцдаг юм. Таны эрхийн эмнэлгийн эмчилгээнд юу тооцохыг Ландстингет шийднэ.

Оргонол хүсч байгаа 18 нас хүрээгүй хүүхэд Шведэд оршин суудаг хүүхэдтэй адилхан эмнүүлхийн эрхтэй юм.

### **Оргонох шалтгаан**

Швед улс орон НҮБ-ийн конвенцийг батласан юм. Тийм учраас Швед улс орогнол хүсэгч хүмүүсийн өргөдлийг судлан шалгах ёстой. Хэрэв та конвенцид зохицуулан дүрвэгч болох эсвэл хамгаалал шаардлагатай хүн бол Швед танд орогнол олгох ёстой. ЕХ-ны дундын журам бас Швед улсад хамарсан юм.

### **Дүрвэгч**

Дүрвэгчийн конвенц, шведийн хууль, ЕХ-ны журмын дагуу хэрэв танд:

- арьстан гэх шинжээр



- үндэстэн гэх шинжээр
- шашны үзлээр, улс төрийн үзлээр
- хүйс гэх шинжээр
- бэлгийн чиг баримжаа гэх шинжээр эсвэл
- нийгмийн гарал зүйлийн улмаас мөрдөж байгаа явдлаас айх үндэс суурьтай шалтгаан байх бол та дүрвэгч гэж тооцогдож чадна.

Өөрийнхөө орноо засгийн газраас ч мөрдөж магадгүй. Түүнчлэн засгийн газрынх таныг ганц нэг эсвэл бүлэг хүмүүсийн мөрдхөөс хамгаалахгүй эсвэл өмгөөлж хүсэх байхгүй байгаа байж магадгүй.

Дүрвэгчийн конвенц болон дүрвэгчийн хүн гэсэн статус зарлах журам шведийн хуульд шингэсэн юм. Дүрвэгчийн хүн гэсэн статус зарлах бол НҮБ-ийн дүрвэгчийн конвенц болон ЕХ-ны журамд баримтласан олон улсын ухагдахуун юм.

Та дүрвэгч биш ч байгаа бол хамгаалал шаардлагатай хүнд тооцогдож оршин суух эрхтэй болж болно. Хамгаалал шаардлагатай болсон танд хувилбарын хамгаалал шаардлагатай эсвэл бусад талаар хамгаалал шаардлагатай хүний оршин суух эрхийг олгож болно.

#### ***Хувилбарын хамгаалал шаардлагатай хүн гэсэн статус зарлах***

Хэрэв та:

- алах ял
- эрүү шүүлт, хэрцгийгээр, хүний ёсноос гадуур шийтгэх буюу доромжлон харьцах эсвэл
- биедээ зэвсэгт мөргөлдөөнд шархагдах аюулыг болгоомжилж буй бол хуулийн дагуу хувилбарын хамгаалал шаардлагатай хүн юм.

Хувилбарын хамгаалал шаардлагатай хүн гэсэн статус зарлах бол ЕХ-ны журамд баримтласан олон улсын статус зарлах.

#### **Бусад шалтгаан**

##### ***Бусад талаар хамгаалал шаардлагатай хүн гэсэн статус зарлах***

Хэрэв та:

- гаднын эсвэл дотоодын зэвсэгт мөргөлдөөнөөс эсвэл эх орондоо гарсан бусад хэцүү зөрчлөөс хамгаалал шаардлагатай хүн бол,
- түүнчлэн хэрэв та хүнд хүчирхийлэгдэхээс эсвэл цаг бус аюулаас айж
- эх орондоо буцаж харих боломжгүй хүн бол

хуулийн дагуу бусад талаар хамгаалал шаардлагатай юм.

Бусад талаар хамгаалал шаардлагатай хүн гэсэн статус зарлах бол зөвхөн Швед оронд л хүчтэй нь болох шведийн хамгаалал шаардлагатай хүн гэсэн статус зарлах.

#### **Хэрэв таны өргөдлийг хүлээн авбал**

Хэрэв таны өргөдлийг хүлээн авбал танд оршин суух эрх олгоно, өргөдөл нь хүлээн авсан хүмүүсийн олонх нь байнгын оршин суух эрхтэй болдог юм. Байнгын оршин суух эрх бол та Шведэд үлдэж дандаа сууж чадах эрх байна.

#### **Хэрэв таны өргөдлийг татгалзвал**

Хэрэв таны орогнох өргөдлийг татгалзвал, дахин хянаж үзэхийг хүсэх эрх танд бий. Та өмгөөлөгчтэй хамт шүүхийн газарт цагаачлалын албан газрын шийдвэрлэлийг дахин хянахыг хүсч чадах эрхтэй юм.

#### **Урьд гаргасан шийдвэрийг дахин үзэж болно**

Таны хэргийн шийдвэрийг дахин хянан үзэхийг хүсэж шүүхийн газар луу явуулж чадна. Та өмгөөлөгчтэй хамт давж заалдах захиа цагаачлалын албан газар луу явуулах хэрэгтэй байна. Давж заалдах захиаг шийдвэр авсны дараа 21 хоногийн хугацаанд явуулна. Цагаачлалын абан газар таны давж заалдах захиаг цагаачлалын абан газарын шүүхийн газарт явуулна. Давж заалдах захиа шүүхийн газарт хүрэхэд өөрийнхөө өргөдлийн тухай тэнд л ярих хэрэгтэй. Та өмөлөгчтэйгээ бас ярьж болно.

Цагаачлалын шүүхийн шийдвэрийг цагаачлалын ерөнхий шүүх гэдэг газарт давж заалдаж болно.



## **Буцах нь**

Хэрэв танд Шведэд оршин суух эрх олгохгүй бол, та хариу буцах ёстой. Цагаачлалын албан газар таны хариу буцаах явдалд туслаж чадна, өөрийнхөө удирдагчтай зөвшөөрж үз.

## **Хүүхдүүд**

Орогнох хүсэх хүүхэд олонх нь аав ээжийн аль нэгтэй эсвэл хоюултай нь ирдэг юм. 18 нас хүрээгүй бол цагаачлалын алба хүүхдүүд гэж тоолдог юм.

Хүүхдүүд дуу санаагаа мэдүүлэх эрхтэй байна, ёсны журмаар цагаачлалын алба хүүхдийн амар мэндэд онц анхаарлаа тавих ёстой. Бүх хүүхдүүд боломж байвал өөрийнхөө хүслээр дуу санаагаа мэдүүлэх эрхтэй байна.

## **Ээж аав үгүй ирсэн хүүхэд**

Ээж аав үгүй, асрамжлагч үгүй Шведэд ирсэн хүүхдүүдэд заавал асуулт тавьж тэдэнтэй ярих ёстой юм. Хариуцлагатай хүн эсвэл улсаас томилсон дэмжлэг болох хүн ярианд ороцох ёстой.

Хариуцлагатай хүн бол ээж аав нь оролцож чадахгүй учраас хүүхэдийн хууль цаазны эрхийг хамгаалах үүрэгтэй юм байна.

## **Шинэ нөхцөл байдал**

Сүүлчийн татгалзлалыг авсны дараа шинэ мэдээлэл олдвол, цагаачлалын албан газар шинэ мэдээлэл таныг буцаах явдалд саад болохыг хянан үзэж чадна. Цагаачлалын албан газар хянан үзхийг өөрөө эсвэл таны өргөдлөөр хийж чадна. Шинэ нөхцөл байдлын учир нь гэвэл хамгаалахын шинэ шалтгаан гарсан бол, эсвэл эрүүл мэндийн шалтгаан учирч та хүнд өвчтэй болохсон бол.

## **Сайн дурын байгууллагууд**

Танд янз бүрийн сайн дураар элсэгчдийн байгууллага тусалж чадна, жишээвэл, Шведэд оршиж байгаа Улаан загалмай, Зөвлөх товчоо (Rådgivningsbyrån) эсвэл Каритас (Caritas) бий. Цагаачлалын албаны ажилтнууд тийм байгууллага таны орон сууцны газарт олох явдалд тусалж чадна.

## **Нэмэр болгож унших санаатай хүмүүст**

[www.migrationsverket.se](http://www.migrationsverket.se)

Гадаадын иргэний хууль (Utlänningslagen) SFS 2005:714

Гадаадын иргэний дүрэм (Utlänningsförelördningen) SFS 2006:97

Орогнол хүсч байгаа болон бусад зэргийн хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхийн тухай дүрэм (Lag om hälso- och sjukvård åt asylsökande m. fl.) SFS 2008:344

Орогнол хүсч байгаа болон бусад зэргийн хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлэхийн тухай дүрэм (Förelördningen om hälso- och sjukvård åt asylsökande m. fl.) SFS 2008:347

Орогнол хүсч байгаа болон бусад зэргийн хүмүүсийг хүлээж авах хууль (Lag om mottagande av asylsökande m. fl.) SFS 1994:137

Орогнол хүсч байгаа болон бусад зэргийн хүмүүсийг хүлээж авах дүрэм (Förelördningen om mottagande av asylsökande m. fl.) SFS 1994:361

Дублины дүрэм, ЕХ-ны дүрэм (Dublinförelördningen EU-förelördning) nr 343/2003

